



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Энхтайван найрамдлын ордон, Энхтайваны өргөн чөлөө,
3 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 01 82

2024.12.02 № 01/2088
танай _____-ны № _____-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАРТ**

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны
үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга
хэмжээний төлөвлөгөөний 2024 оны биелэлтийг
хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Д. Дорж* ДАЯТАНЦЭЦЭГ



1524 161056

Хүснэгт:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилт

2024 оны 11 дүгээр сарын 29

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
1	1.1.3. Шинэ сэргэн байгаа тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.	1.Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.	2021-2024	Улсын төсөв	Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийгдэж, нөөцийг шинэчилж сэлгэсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А/211 дүгээр тушаалын хэрэгжилт, болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг үнэлэх 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн батлагдсан удирдамжийн дагуу эрүүл мэндийн байгууллагын нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, оношлуур зэрэг 6 бүлгийн 119 нэрийн бүтээгдэхүүний нөөц, тасалдлын мэдээллийг авч нэгтгэн, үнэлгээ хийсэн. Үнэлгээнд төв эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв 21, нэгдсэн эмнэлэг 25, сум тосгоны эрүүл мэндийн төв 23, орон нутгийн өрхийн эрүүл мэндийн төв 21 нийт 110 эрүүл мэндийн байгууллага тус бүрээр эм, эмнэлгийн хэрэгсэлийн бэлэн байгаа нөөцийн хэмжээг ширхэг нэгжээр нэгтгэж, нөөц хүрэлцэх хугацааг тооцоолоход: - Амилуулах тусламж, үйлчилгээний эм 1.5 сарын; - Булчин сулруулах, унтуулах эм (Атракурын безилат 10мг/мл, Неостигмин 2.5мг-1мл) - 2 сарын; - Антибиотик эм (Цефазолин 1000мг, Левофлоксацин 5мг/мл-100мл, Цефатаксим 1000мг) – 2.5-3 сарын; - Өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг эм (Ацетаминофен, Метамизол натри 50%-2мл, Диклофенак 75мг-3мл) 2 сарын; - Шээс хөөх эм (Фуросемид тарилгын уусмал, 1%-2мл) 2 сарын;	ЭХГ	

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						- Харшлын эм (Дексаметазон тарилгын уусмал, 4мг/мл, Преднизолон 30мг/мл-1мл) 2.5-3 сарын; - Бусад яаралтай тусламжийн эм (Аминокапроны хүчил 5%-100мл, Атропин сульфат 1мг/мл) 2 сарын тус тус нөөцтэй байна.		
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
2.1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.								
2	2.1.8. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	1.Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтыг нэвтрүүлнэ	2021-2024	-	Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналт эм хангамжийн байгууллагуудад бүрэн нэвтэрсэн байна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог цахимжуулах ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд: 1. Иргэд, эрүүл мэндийн байгууллагыг чанарын баталгаатай, аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслээр хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг тасралтгүй, жигд хүртээмжтэй хангах зорилгоор төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр дамжуулан эм хангамжийн байгууллагын шатлал бүрд эмийн нэр төрөл, үнэ, цувралын мэдээлэл солилцох байгууллага хоорондын цахим мэдээллийн нэгдсэн тогтолцооны хөгжүүлэлтийг үе шаттай хийгдсэн. Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас Ай Пи хаяг авч, Лайсмед программын серверийг Мэдээллийн аюулгүй байдлын газрын сүлжээнд холболт хийж, Гаалийн ерөнхий газартай 2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн ГЕГ15/24 дугаар хамтран ажиллах гэрээ байгуулж, Гаалийн автоматжуулсан мэдээллийн системтэй 36 төрлийн мэдээлэл солилцож, эмийн импортийг бүрэн цахимжуулаад байна. 2. Лайсмед программын эмийн мэдээллийг баркодоор лавлах сервисийг төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д нээлттэй	ЭХГ ЭБХ ЗАБТСГ	

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						байршуулсан нь эмийн сангийн программ хөгжүүлэгч байгууллагуудад эмийн мэдээллийг хүртээмжтэй ашиглах боломж бүрдүүлсэн. 3. Эмийн үнийн өсөлтөд олон нийтээс тавих хяналтыг бий болгох зорилгоор импортын эм, эмнэлгийн хэрэгслийн гаалиар орж ирсэн үнэ, тоо хэмжээ, зах зээлд борлуулагдсан бөөний болон жижиглэнгийн үнэ, тоо хэмжээний мэдээлэл солилцох, эмийн үнийн шатлал бүр дэх нэмэгдлийн хэмжээг хянах зорилгоор Татварын ерөнхий газар болон Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр ТEG-01/36 дугаартай хамтран ажиллах гэрээний дагуу дараах мэдээллийг солилцож хамтран ажиллаж байна. Үүнд: - Эмийн зах зээлийн дараах чанар аюулгүй байдлын хяналтыг цувралын дугаараар мөшгөх тогтолцоо бий болох зорилгоор эм, эмнэлгийн хэрэгсэлийг худалдан борлуулахад Цахим төлбөрийн баримтын систем "POS API 3.0"-д цувралын дугаараар бүртгэгдэх боломжийг бүрдүүлж, и-баримтын загварт цувралын дугаар хэвлэх. Ингэснээр иргэний эмийн сангаас худалдан авсан эм дээрх цувралын дугаар и-баримтын цувралын дугаартай ижил болсон. Ингэснээр хууль бус болон хуурамч эмийн эргэлтийг илрүүлэх, таслан зогсоох ач холбогдолтой юм. - Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн удирдлага, үнийн өсөлтөд хяналтын тогтолцоо бүрдүүлэхээр Цахим төлбөрийн баримтын системээс эм хангамжийн байгууллагын борлуулсан тоо хэмжээ, бөөний үнэ, жижиглэнгийн үнийн мэдээллийг ирүүлэх;		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						- Дээрх мэдээллийг дашбординд хэлбэрээр Засгийн газрын "Их өгөгдлийн (big data) сан"-д тогтмол нийлүүлэх зэрэг болно. 4. Дийг Ай Ти ХХК-тай "Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын суурь системийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах" ЭЭХХЗГ/03/28 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын нэгдсэн системийн ажлын даалгавар боловсруулж, ЭМХТ-ийн Мэдээлэл технологийн алба тус ажлын даалгаврын дагуу эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт, хяналтын цахим тогтолцоог нэвтрүүлэх программын хөгжүүлэлтийг эхлүүлэн хамтран ажиллаж байна. 5. Эмийн гаж нөлөө, аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн мэдээлэх иРепортинг цахим системийг эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан, өрх, сум тосгоны ЭМТ-д бүрэн нэвтрүүлсэн. Жилийн эцсийн байдлаар нийт 218 тохиодол иРепортинг системээр мэдээлэгдсэн байна. 6. Эмийн мэдээллийг И-Монголиа цахим системтэй холбох ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд: - И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газарт Вакцины бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн үйл ажиллагаа болон Биобэлдмэлийн бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн үйл ажиллагааг цахимжуулах хүсэлтийг хүргүүлж, 5 дугаар сарын 03-ны өдрөөс үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн. - Жорыг цахимаар бичдэг болж, E-Mongolia системээр дамжуулан авсан эмийн түүх болон гаж нөлөөг мэдээлж байна. - Жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны хүсэлт		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						хүлээн авах, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг И-Монголиа цахим системээр 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлж, 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар 52 хүсэлт хүлээн авсан байна. Эмийн зар сурталчилгааны зөвшөөрлийн онцлог нь агуулгыг засаж олгогддог зөвшөөрлийн үйл ажиллагаа тул зар сурталчилгааны зөвшөөрлийн агуулгыг И-Монголиа цахим системээр зөвхөн PDF файл хүсэлт хүлээн авдаг байсныг word файлаар хүлээн авдаг болсон. “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-д эмнэлгийн хэрэгслийн зар сурталчилгааны зөвшөөрөл олгогдох болсон тул цахим систем дэх зөвшөөрлийн нэрийг шинэчлэх хүсэлтийг 01/1545 дугаар албан бичгээр хүргүүлж, нэрийг өөрчилсөн. AR-Монголиа хиймэл оюун ухааны апп-тай хамтран 100 эмийн хэрэглэх зааварт хяналт хийж, иргэд эмийн хэрэглэх зааврыг И-Монголиа цахим системээр харахаар холбосон.		
3		3.Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлнэ	2022-2024	1,000.0 Улсын төсөв	Арга хэмжээний төлөвлөгөөт үйл ажиллагааны хэрэгжилт 80 хувь	1. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/450 дугаар тушаалаар “Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2022-2025 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 3 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсралт 2. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/76 дугаар тушаалаар Эм, биобэлдмэлийн үйлдвэр, эмийн сангийн үйл ажиллагааг шалгах, эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний	ЗУГ	

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						хадгалалт, түгээлтийг шалгах, эрүүл мэндийн байгууллагын эм зүйн тусламж, үйлчилгээг шалгах хяналт шалгалтын хяналтын хуудсыг батлуулсан. 3. "Хүүхдийн хорт хавдрын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформ" санаачлагыг хэрэгжүүлэх төслийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд: - Тус төслийн хүрээнд нийлүүлэгдэж буй эмийг хүлээн авахтай холбоотойгоор хил дээрх зохицуулалтад оролцогч талуудын уулзалт, эм хүлээн авагч ЭХЭМҮТ, ЗӨСҮТ-ийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан. - Хүүхдийн хорт хавдрын тусламж, үйлчилгээнд шаардлагатай 30 гаруй нэр төрлийн эмийг 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр ДЭМБ-аас ЭМЯ, ЭХЭМҮТ-д хүлээлгэн өгсөн. - Эмийн хадгалалт, түгээлтийн суурь стандартуудыг боловсруулахаар "Эс хордуулах эмийн зааврыг ДЭМБ болон бусад улс орны гарын авлага"-ыг орчуулж, стандарт ажлын заавар боловсруулж, 6 сарын 13-ны өдөр төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын эмийн 40 мэргэжилтнүүдэд танилцуулах сургалтыг зохион байгуулсан. - ДЭМБ, Сэйнт Жүд хүүхдийн хавдарын эмнэлгийн төлөөлөгчидтэй хамтран оролцогч талуудад 10 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд эм, эмнэлгийн хэрэгслийн төв агуулах болон хилийн боомт дээрх эм хадгалалтын процессийн танилцуулга, "Бараа материалын удирдлагын загвар стандарт" үйл ажиллагааны САЗ болон тэдгээрийг тухайн улсын нөхцөл байдалд тохируулан авч үзэх практик сургалт, эмнэлзүйн		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						САЗ-ын семинар болон улс орны нөхцөл байдалд зохицуулах практик сургалт зохион байгуулж, эм хүлээн авах 2023-2027 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан. 4. Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 42 дугаар тогтоолоор батлагдсан журмын хүрээнд Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх 99 нэр төрлийн эм, эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх 225 нэрийн эм нийт 324 нэрийн эмийн үнийн санал авах хүсэлтийг НҮБ-ын Хүүхдийн санд 3 дугаар сарын 22-ны өдөр хүргүүлсэн. Үнийн санал авах жагсаалтад багтсан 51 нэрийн эмийн тунг өөрчлөх, захиалгын тоо хэмжээг дахин баталгаажуулах саналыг НҮБ-ын Хүүхдийн сангаас 5 дугаар сарын 07-ны өдөр цахим шуудангаар мэдэгдсэн. Саналын дагуу төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 01/750, 01/751 дугаар албан бичиг тус тус хүргүүлж, санал авч, нэгтгэн 5 дугаар сарын 16-ны өдөр цахим шуудангаар НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлсэн. НҮБ-ын Хүүхдийн сангаас цахим каталогит үнэ байршсан 58 нэрийн эмийн үнийн саналыг 6 дугаар сарын нэгдүгээр 7 хоногт ирүүлэх ба бусад нэрийн эмийн тендерийн үйл ажиллагаа явагдаж байгаа тухай мэдээллийг 6 дугаар сарын 04-ний өдөр ирүүлсэн. 5. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг олон улсын байгууллага болон гадаад улсын үйлдвэрлэгч, ДЭМБ-аас эмийн		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						зохицуулалт, хяналтыг өндөр түвшинд гүйцэтгэдэг улсаас шууд болон дамжуулан худалдан авах эрхзүйн зохицуулалтын хүрээнд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгож буй 18 нэр төрлийн эмийг худалдан авахаар үнийн хэлцэл хийсэн. Үүний дагуу БНСУ-ын "DONGKOO BIO & PHARM" эмийн үйлдвэртэй ЭМЯ болон ЭЗХХЗГ хамтын ажиллагааны гэрээ байгуулж, 5 нэрийн эмийг нэг эх үүсвэрээс худалдан авалт хийж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47.5 дахь хэсгийг үндэслэн НЗҮ-ийн аргаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Dongkoo Bio Pharma үйлдвэрээс худалдан авах 5 нэрийн эмийн дотоодын Ложистикийн үйлчилгээ авах тендерийг 10 дугаар сарын 29-ний өдөр зарласан бөгөөд, тус тендерт Азифарма ХХК шалгарсан.		
5	2.1.8.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	5.Эмийн зохицуулалтын төрийн захиргааны байгууллага байгуулна.	2021-2024	-	Эмийн зохицуулалтын төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа жигдэрсэн байна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2024-2027 оны стратеги төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталсан. Мөн хүний нөөцийн сул орон тоог нөхөхөөр ЭМЯ-ны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2024 онд нийт 8 удаагийн албан бичгээр удирдах-3, гүйцэтгэх-17 сул орон тооны захиалгыг хүргүүлсэн байна. 01 дүгээр сарын 30-ны өдрийн шалгалтаар гүйцэтгэх албан тушаалын 2 сул орон тоо нөхөгдсөн. Жилийн эцсийн байдлаар төрийн захиргааны-74, төрийн үйлчилгээний-26, төрийн үйлчилгээ мэргэжлийн-8, гэрээт-10 албан хаагч ажиллаж байна.	ЗУГ	
6		6.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тэргүүлэх чиглэлийг үндэслэн	2021-2024	-	Эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн дотоодын зах зээлд эзлэх хувь 21.0 байсан. Дотоодын эмийн үйлдвэрүүдээс 2023 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тайланг авч дүн шинжилгээ хийж, Эм зүйн салбарын үзүүлэлт номонд оруулсан. 2024 оны эмнэлгийн хэрэгслийн	ЭХ		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
		эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ				Үйлдвэрлэлийн дотоодын зах зээлд эзлэх хувийг 2025 оны 1-2-р сард авч нэгтгэдэг. Эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих арга хэмжээний хүрээнд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47-р зүйлийн 47.18, 47.19 заалтуудыг оруулж батлуулсан. Тус заалтын хүрээнд дараах ажил хийгдсэн байна. Үүнд: 1. “Эмнэлгийн хэрэгсэл-Чанарын менежментийн тогтолцоо-Зохицуулалтын зорилгоор тавих шаардлага” MNS:ISO 13485:2021 стандартын гарын авлагыг Азийн Хөгжлийн Банкны 6652-MOH төслийн санхүүжилт, дэмжлэгтэйгээр орчуулж, 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр “MNS ISO 13485:2021, MNS 5524:2014 стандартын хэрэгжилтийг сайжруулах нь” сургалтын удирдамж, төлөвлөгөөг батлуулж Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 6 эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрийн 12 мэргэжилтнүүдийг хамруулж MNS-ISO 13485:2021 стандартыг хэрхэн хэрэгжүүлэх тухай сургалтыг зохион байгуулж, тус стандартыг хэрэгжүүлэх гарын авлагын орчуулсан хувилбарыг үйлдвэрүүдэд хүлээлгэн өгсөн. 2. Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрийг эдийн засгийн чадавхийг бодлогын түвшинд дэмжих зорилгоор эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр болох Монэнзим Мед ХХК, Энхийн шүүдэр ХХК-ийн дотооддоо үйлдвэрлэж буй тариурыг Ерөнхий гэрээгээр барааг цахим дэлгүүрээр худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Эм хангамжийн газарт №7296 дотоод меморандумаар хүргүүлсэн. Эм хангамжийн газар 2024 оны 11-р сарын 22-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газарт цахим дэлгүүрт нэр		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
7		7.Биобэлд мэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ	2021-2024	2,000.0 Улсын төсөв	Биобэлдмэл, тэжээлт орчны үйлдвэрлэл 35 хувиар өссөн байна.	терөл нэмүүлэх тухай 01/2043 албан бичгийг хүргүүлсэн. 1. НЭМҮТ-ийн Биобэлдмэлийн үйлдвэрийн тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлтийн дагуу 4 дүгээр сарын 08-ны өдөр үйлдвэрийн ажлын байранд үнэлгээ хийж, тусгай зөвшөөрлийн 4 дүгээр 10-ны өдрийн хурлын комиссд танилцуулж дэмжигдсэн шийдвэр гарч хугацааг сунгасан. Мөн тус үйлдвэрийг Эм үйлдвэрлэлийн зохистой дадал буюу GMP-д нийцүүлэх зорилгоор агентлагийн даргын 09/2067 дугаар албан бичгээр үйлдвэрийн мастер баримт бичиг, өөрийн үнэлгээний тайлан, мастер томъёолол, баримт бичгийн хяналтын журам зэрэг үндсэн баримт бичгүүдийн загварыг хүргүүлсэн. 2. “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийн 47.18-д Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, дотоодын эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлд ашиглах түүхий эд, сав, баглаа боодол, тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж болно. 47.19-д Импортыг орлох, экспортыг дэмжих, инновац шингэсэн дотоодын үйлдвэрийн шинэ эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, эсхүл алслагдсан бүс нутагт эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, экспортлох үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг олгож болно гэсэн үйлдвэрлэл дэмжсэн зохицуулалтыг тусгасан.	ЗҮХ	
8		8.Эмийн аюулгүй байдлын үндэсний лаборатори байгуулна	2024	90.0 Улсын төсөв, гадаадын зээл тусламж	Эмийн аюулгүй байдлын үндэсний лаборатори байгуулах ТЭЗҮ-г боловсруулан	Эмийн лабораторийн чадавхийг бэхжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт, тооцоог гаргаж, Эм шинжлэх лабораторид нэн шаардлагатай 17 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмж болох Өндөр идэвхит шингэний хроматографи, уусалтын аппарат, спектрофотометр,	ЭШЛ	

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
					батлагдсан байна.	вискозиметр, поляриметр, кьелдалийн аппарат, потенциометрийн титрлэгч, шатаах зуух, хатаах зуух, зөөврийн бактерицидны ламп, рН метр, соронзон хутгагчтай халаагуур, ультрасоник, лабораторийн плетка, аналитиз жин, Атом шингээлтийн спектрофотометрийг авч үйл ажиллагаанд ашиглаж байна. Эмийн аюулгүй байдлын үндэсний лаборатори байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулахад шаардлагатай тендерийн үнийн зах зээлийн үнийн судалгааг хийж дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд: 1. Шаардлагатай багажны жагсаалт гарган зах зээлийн үнийн судалгаа 2. Урвалж бодис, стандартын үнийн судалгаа 3. Лабораторийн өрөө тасалгааны байршил, хэмжээ 4. Хүний нөөцийн судалгаа Багаж тоног төхөөрөмжийг угсарч суурилуулан, үйлдвэрийн инженерээр сургалт зохион байгуулж, багаж ажиллуулах стандарт ажлын зааврыг боловсруулж, туршилтын шинжилгээ хийж, мөн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж, эм, эмнэлгийн хэрэгсэлд 150 дээжид 300 үзүүлэлтээр үзүүлэлтээр шинжилгээ хийж байна.		
9	9.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ	2021-2024	500.0 Улсын төсөв	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоотой болно.	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санд жилийн эцсийн байдлаар 601 эрүүл мэндийн байгууллагын 1,223 хэрэглэгч, 33,332 эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгдсэн байна. Үүнээс ЭМЯ-ны харьяа 15 эрүүл мэндийн байгууллагад 4,254, нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 18 эрүүл мэндийн байгууллагад 2,365, орон нутгийн харьяа 317 эрүүл мэндийн байгууллагад 8,583 буюу нийт 350 эрүүл мэндийн байгууллагад 10 ба түүнээс дээш жил ашигласан 15,202 эмнэлгийн тоног төхөөрөмж байна.	ЭТГ		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						“Эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжид 2024 онд шалгалт тохируулга хийх хуваарь”-ийг батлуулж, нийт 214 эрүүл мэндийн байгууллагын 2435 эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийсэн. Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хүрээнд Польш Улсын Storalczyk Mirosław Technologia Pozarnicza компанитай MON/2021-005-0723 дугаартай гэрээ байгуулсан. Уг гэрээ болон Эрүүл мэндийн сайдын 2024 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/327 дугаар “Түргэн тусламжийн автомашиныг орлогод авч, хуваарилах тухай” тушаалын 1 автомашин, 5 нэр төрлийн 9 хэмжилийн тоног төхөөрөмжийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр бүрэн хүлээж авч хөдөө орон нутагт шалгалт тохируулгын явуулын лабораторийг ажиллуулах нөхцөл бүрдсэн. Мөн АХБ-ны “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” L3843/3844/G0672-MON төсөл (1-р үе шат)-ийн 2024 оны ажлын төлөвлөгөөнд “Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудад барилга, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хугацааг сануулах, түүх үүсгэх бүртгэлийн программ хангамж (recall system) боловсруулж, батлуулах, холбогдох сургалтыг зохион байгуулах” ажлыг хийхээр бэлтгэлийг хангаж байна.		

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

2024 оны 11 дүгээр сарын 29

д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Биелэлт	
Зорилт 1: Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлын удирдлага, эрхзүйн орчныг сайжруулж, эм шинжлэх лабораторийн чадавхийг бэхжүүлэн, орчин үеийн шинжилгээний арга аргачлалыг нэвтрүүлэх						
1.	Арга хэмжээ 1.3 Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх	ЭЭХХЗГ	Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн гэрчилгээ	Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын үйл ажиллагааны чиглэлүүд үр дүнтэй хэрэгжинэ.	- Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үйл ажиллагаанд ДЭМБ-ын "Үндэсний зохицуулалтын байгууллагад чанарын менежментийг хэрэгжүүлэх шаардлага" удирдамж болон Олон улсын ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор "Чанарын менежментийн тогтолцоо, ач холбогдол" сургалтыг байгууллагын нийт албан хаагчдад 2024 оны 3 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. - Тус стандартыг нэвтрүүлэхэд зөвлөх үйлчилгээ авах зарыг байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулж, нэг байгууллагаас үнийн санал ирүүлснийг чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх ажлын хэсгийн дарга, удирдлагуудад танилцуулсан. - Байгууллагын 2025 оны төсвийн төсөөлөлд тус тогтолцоог нэвтрүүлэхэд шаардагдах зардлыг тооцож, зардлын нэгдсэн төсөв гарган оруулсан.	30
2.	Арга хэмжээ 1.4 Эм шинжлэх лабораторийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, сэлбэх, шинэчлэх шаардлагатай аппарат, тоног төхөөрөмжийн тооцооллыг хийж, санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээ авах	ЭЭХХЗГ	Үнэлгээний тайлан	Эм, эмнэлгийн хэрэгслийг шаардлагатай бүх үзүүлэлтээр шинжилдэг болсон байна.	Эм шинжлэх лабораторийн тоног төхөөрөмжид лабораторийн багаж, тоног хариуцсан инженерээр үнэлгээ хийлгэж, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн судалгаа, үнийн саналыг гарган дараах албан бичгийг хүргүүлсэн. Үүнд: 1. ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтэст 01/494 дугаар албан бичиг 2. ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт 01/15 дугаар албан бичиг 3. 2025 онд нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, урвалж бодисын төсвийг гаргаж, ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газарт 01/434 дугаар албан бичгээр хүргүүлсэн. ЭМЯ, ДЭМБ-ын дэмжлэгтэй төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу тендер зохион байгуулж, дараах багаж тоног төхөөрөмжийг худалдан авсан байна. Үүнд:	90

					- Нэн шаардлагатай 10 тоног төхөөрөмж болох хатаах шүүгээ, шатаах зуух, соронзон хутгуур, лабораторийн плитка, принтертэй аналитик жин, рН метр, ультрасоник, компьютер - Өндөр идэвхт шингэний хроматографын багаж, уусалтын аппарат, спектрофотометр, потенциометрийн титрлэгч, автомат поляриметр, кьелдалын аппарат - Атом шингээлтийн спектрофотометр Багаж тоног төхөөрөмжийг угсарч суурилуулан, үйлдвэрийн инженерээр сургалт зохион байгуулж, багаж ажиллуулах стандарт ажлын зааврыг боловсруулж, туршилтын шинжилгээ хийж, мөн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж, эм, эмнэлгийн хэрэгсэлд 150 дээжид 300 үзүүлэлтээр үзүүлэлтээр шинжилгээ хийж байна				
3.	Арга хэмжээ 1.6 ДЭМБ-ын эм шинжлэх лабораторийн сүлжээнд нэгдэх	ЭЭХХЗГ	Сүлжээнд нэгдэх хүсэлтээ ДЭМБ-д албажуулан илгээсэн байна.	Бүсийн болон улс гадны орнуудын ижил төстэй лабораторитой хамтын ажилладаг болсон байна.	ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч, НДБЭБ-ийн Эмийн тогтолцооны газрын Зайлшгүй шаардлагатай эм, технологийн асуудал хариуцсан зохицуулагч нар 2024 оны 3 дугаар сарын 13-ны өдөр лабораторийн үйл ажиллагаатай танилцаж, ДЭМБ-ын эмийн лабораторийн сүлжээнд хэрхэн нэгдэх талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. Тус сүлжээнд нэгдэхийн тул вакцины цуврал чөлөөлөх тогтолцоог хэрэгжүүлэх шаардлагатай учраас 6 албан хаагчийн вакцины нэгж цувралыг чөлөөлөх тогтолцоог нэвтрүүлэхэдтэй холбоотой сургалтад хамруулсан.	30			
4.	Арга хэмжээ 1.7 Вакцины нэгж цувралыг чөлөөлөх тогтолцоог нэвтрүүлэх	ЭЭХХЗГ	Тушаал гарсан байна.	Вакцины чанар, аюулгүй байдалд тавих хяналт сайжирсан байна.	Вакцины нэгж цувралыг чөлөөлөх тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд БНСУ-ын Сөүл дэх "Global trainin Hub for Biomanufacturing"-аас 6 дугаар сарын 3-14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Introductory course for biologics development and manufacturing 2024" сургалтад 2 албан хаагчийг, 6 дугаар сарын 17-25-ны өдрүүдэд "National Institute Of Food and Drug Safety Evalution"-аас зохион байгуулсан "7th training on quality control of biologicals in the Asia-Pacific region – Vaccine track" 5 хоногийн сургалтад 1 албан хаагчийг, "2024 introductory course for standard practice (GxP), Ich good clinical practise E6 (R2)" 21 хоногийн сургалтад 2 албан хаагчийг, "Цар тахал болон бусад өвчний дэгдэлттэй тэмцэх Азийн оношлогоо вакцин эмчилгээний зохицуулагчдын удирдлага"-ын уулзалт, хэлэлцүүлэгт 1 албан хаагчийг тус тус хамруулсан. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл /ДДУХ/-ийн 2021-2024 оны мэдээнд дүн шинжилгээ хийсэн. 2021 онд 37, 2022	30			

					онд 18, 2023 онд 23, 2024 онд 7 нийт 85 ДДУХ-ийн мэдээ хүлээн авч, холбогдох арга хэмжээг авсан байна. Улсын хэмжээнд ДДУХ бүртгэн мэдээлэх үйл ажиллагаанд e-Reporting цахим системийн хэрэглээг нэвтрүүлж, 2021-2024 онд үндэсний (Vigiflow) мэдээний санд 30, олон улсын (Vigilyze) нэгдсэн мэдээний санд 9 ДДУХ-ийн тохиолдлыг мэдээлсэн байна.					
5.	Арга хэмжээ 1.8 Лабораторийн мэдээллийн удирдлагын системийг бүрэн цахимжуулж, ил тод байдлыг хангах	ЭЭХХЗГ	Цахимжсан үйл ажиллагааны тоо	Лабораторийн үйл ажиллагаа хүнд сурталгүй, ил тод явагддаг болсон байна.	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газрын Процессын дахин инженерчлэл хийх ажлын хүрээнд цахим программыг сайжруулах ажлын алба Эрүүл мэндийн хөгжлийн төвд байгуулагдаж, лабораторийн удирдлагын менежментийн тогтолцоо LIMS-ыг программыг сайжруулахаар ажиллаж байна. LIMS цахим программд 2024 оны 11 сарын байдлаар нийт 2257 дээжийг 18056 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн талаарх мэдээллийг байршуулсан байна. Үүнд: - Сунгалт 670 - Өөрчлөлт 24 - MNS төсөл 15 - ҮФӨ төсөл 84 - Хяналт 803 - Байцаагч 82 - Шинэ бүртгэл 566 - Тандалт судалгаа 3 - Гомдол дагуу 10 дээжинд шинжилгээ тус тус хийсэн байна. Үүнээс шаардлага хангаагүй дээж 74 байсан.	70				
6.	Арга хэмжээ 1.11 Эм зүй, тоног төхөөрөмж, биологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотой стандартыг шинэчлэн сайжруулах	ЭЭХХЗГ	Батлагдсан стандартын тоо	Бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал сайжирч, хяналт тавих боломж бүрдэнэ.	1. Эмнэлгийн хий ба вакум хоолойн систем стандарт ("ISO 7396-1:2016 Эмнэлгийн хий дамжуулах хоолойн систем 1-р хэсэг)-ын төсөлд Барилгын хөгжлийн төвөөс санал авахаар 2024 оны 01/593 дугаар албан бичиг хүргүүлсэн. Ирүүлсэн саналыг стандартын төсөлд тусгаж, стандартын төслийг 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 01/846 дугаар албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн. 2. "Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага" MNS 5524:2014 стандартыг шинэчлэх ажлын хэсгийг агентлагийн даргын 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар байгуулж, стандартын төслийг боловсруулж, 8 дугаар 20-ны өдөр байгууллагын цахим хуудаст байршуулсан. "Монголын эмзүйн байгууллагуудын нэгдсэн ЭМ холбоо", "Эмзүйч мэргэжлээр төгсөгчдийн холбоо", "Эм хангамжийн холбоо", "Монголын эмзүйн ажилтны холбоо"	90				

					руу 01/1310, 01/1311, 01/1312, 01/1313 дугаар албан бичгээр санал авахаар хүргүүлсэн. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрүүдэд 9 дүгээр сарын 17, 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд стандартын төслийг 2 удаа танилцуулж, хэлэлцүүлсэн. Холбоодоос ирсэн санал болон хэлэлцүүлгийн үеэр гарсан саналуудыг нэгтгэж, 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/2059 дугаар албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн.				
7.	Арга хэмжээ 1.12 MNS 5530:2014. Эрүүл мэндийн технологи. Эм эмнэлгийн хэрэгслийн хадгалалт түгээлтэд тавигдах шаардлага стандартыг шинэчлэн батлуулах	ЭМЯ	Батлагдсан стандарт	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжирна.	“Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага” MNS 5530:2014 стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулж, стандартын төсөлд санал авахаар аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газруудад 3 дугаар сарын 22-ны өдрийн 01/451 дугаар албан бичгээр, Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн эм холбоо ТББ, Монголын эм хангамжийн байгууллагуудын холбоо ТББ, Эм зүйн мэргэжлээр төгсөгчдийн холбоо ТББ, Клиник эмзүйчдийн нэгдсэн холбоо ТББ-д 3 дугаар сарын 11-ний өдрийн 04/381 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн ба нийт 9 аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраас стандартад оруулах саналыг тус тус ирүүлсэн. Нийт ажлын хэсэг хурлыг 8 удаа, Стандартын шинэчилсэн төслийг танилцуулж, холбоодууд болон эм хангамжийн байгууллагуудтай хэлэлцүүлэг 3 удаа зохион байгуулж, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлэхээр бэлэн болсон.	90			
8.	Арга хэмжээ 1.14 Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартыг шинэчлэн батлуулах	ЭМЯ	Батлагдсан стандарт	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжирна.	Агегтлагийн даргын 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/154 дүгээр тушаалаар ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн удирдамж болон ажлын төлөвлөгөөг батлуулсан. Ажлын хэсгийн хурлыг 8 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж, эмийн санд үнэлгээ хийх асуумжийг 1-р зэрэглэлийн эмийн сан, 2-р зэрэглэлийг эмийн сан, эмнэлгийн эмийн сан хийхээр асуумжийг боловсруулж, нийт 355 эмийн санд үнэлгээ хийсэн. Ажлын хэсгийн 2 дах хурлыг 10 дугаар сарын 17-ны зохион байгуулж, стандартын төслийг боловсруулсан. Аймгийн эрүүл мэндийн газар, БОЭТ, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, холбоодоос санал авахаар албан бичиг хүргүүлж, нийт 20 гаран байгууллагаас 180 гаруй санал ирүүлсэн. Үнэлгээний дүн болон ирсэн саналыг тусган стандартын төслийг эхний байдлаар гаргасан. Эмнэлгийн эмийн сан болон нийтийн үйлчилгээтэй	50			

						эмийн сангийн төлөөллүүдтэй хэлэлцүүлэг хийхээр төлөвлөсөн байна.	
Зорилт 2: Зах зээлд хуурамч, стандартын бус эм, эмнэлгийн хэрэгсэл нэвтрэхээс сэргийлэх чиглэлээр эмийн бүртгэлд сүүлийн үеийн зохицуулалтыг нэвтрүүлж, үндэсний эмийн чанар, аюулгүй байдлыг сайжруулах, зах зээлийн дараах тандалт судалгааг идэвхжүүлэх							
9.	Арга хэмжээ 2.1 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед нэн шаардлагатай эмэнд яаралтай горимоор зөвшөөрөл олгох, журмыг бүртгэх батлуулах	ЭЭХХЗГ	Батлагдсан тушаал	Яаралтай тохиолдолд эм импортлоход эрх зүйн орчин бүрдэж, чирэгдэлгүй болсон байна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 18 дугаар зүйл "Нөхцөлт зөвшөөрөл" гэсэн зүйлийг нэмж тусгасан.	70	
10.	Арга хэмжээ 2.2 Эмийн бүртгэлийн тогтолцоонд ДЭМБ-ын хатуу зохицуулалттай орнуудад "итгэл үзүүлэх, хүлээн зөвшөөрөх" бодлогын хүрээнд хамтран ажиллах улс орны боломжийг судлах	ЭЭХХЗГ	Хамтын ажиллагааны санамж бичиг	Хатуу зохицуулалттай орны эмийн бүртгэл, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нэвтрүүлсэн байна.	Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн журмыг шинэчлэн боловсруулж, төслийг 2024 оны 01/05 албан дугаар бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн. Журмын төслийн 2.1-д ДЭМБ-ын урьдчилсан баталгаажилтад хамрагдсан, ДЭМБ-ын жагсаалтад эмийн зохицуулалтын төлөвшлийн 3 болон түүнээс дээш түвшингээр үнэлэгдсэн эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн, эм, вакцин, оношлуурыг түргэвчилсэн хэлбэрээр бүртгэх заалт оруулсан. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 15 дугаар зүйл Эм, эмийн үйлчлэгч бодисыг бүртгэхэд тавигдах шалгуурын 15.3.7 дахь хэсэгт "итгэлцлийн зохистой дадлыг хэрэгжүүлэх" гэж тусгасан.	70	
11.	Арга хэмжээ 2.3 Өндөр эрсдэлтэй эмнэлгийн хэрэгслийг бүртгэдэг болох	ЭЭХХЗГ	Хуулийн заалт, тушаал батлагдсан байна.	Эмнэлгийн хэрэгсэлд тавих хяналт сайжирсан байна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд "Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага өндөр, дунд эрсдэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг үйлдвэрлэгчийн хүсэлт, техникийн баримт бичиг, Эмнэлгийн хэрэгслийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн энэ хуулийн 33.2.2-т заасан жагсаалтад оруулна", "Өндөр, дунд эрсдэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч, загвар, эсхүл бүтээгдэхүүний дугаар тус бүрээр нь жагсаалтад оруулна" гэж тус тус тусгаж батлуулсан. Батлагдсан хуулийн 15.4-т заасны дагуу Эм, эмийн үйлчлэгч бодис, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх журмын төслийг боловсруулж, журмын төсөлд санал авахаар байгууллагын цахим хуудсанд 2024 оны 8 дугаар 13, 10 сарын 30-ны өдөр тус тус байршуулсан.	50	

12.	Арга хэмжээ 2.5 Эмийн бүртгэл, тусгай зөвшөөрөл, лицензийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, ил тод байдлыг хангах	ЭЗХХЗГ	Цахимжсан үйл ажиллагааны тоо	Бүртгэлийн үйл ажиллагаа нийтэд ил тод, хариуцлагатай болсон байна.	1.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох E-business платформоор 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 2922 хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүнд: - Импортын эмийн өөрчлөлтийн үйл ажиллагаа 626 хүсэлт - Импортын эмийн хугацаа сунгалтын үйл ажиллагаа 364 хүсэлт - Үндэсний үйлдвэр, уламжлалт эм, эмийн түүхий эдийн бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн үйл ажиллагаа 244 хүсэлт - Оношлуурын бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн үйл ажиллагаа 689 хүсэлт - Импортын эмийн бүртгэлийн үйл ажиллагаа 239 хүсэлт - Биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн үйл ажиллагаа 760 хүсэлт байна. 2.Тусгай зөвшөөрөл олгох, импортын бүртгэлээр /лиценз/ хүсэх, авах үйл ажиллагаа 100 хувь цахимжиж, 241 тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Тусгай зөвшөөрөл олгох комиссын 14 удаагийн хурлаар, хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. Үүнд: - Шинээр тусгай зөвшөөрөл-95 - Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгалт-51 - Сунгалт, хаягийн өөрчлөлт-21 - Хаягийн өөрчлөлт /дангаар/-11 - Төсөл болон ажлын байр дэмжигдээгүй-41 - Гэрчилгээ гээгдүүлж дахин олгосон-1 - Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох-2 - Түдгэлзүүлсэн-8 - Агуулах нэмсэн-2 - Сунгалт, агуулах нэмсэн-1 - Сунгалт, чиглэл хэсэгчлэн түтгэлдүүлсэн-3 - Эрх сэргээсэн-3 Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын бүртгэл авах нийт 8946 хүсэлтийг цахимаар хүлээн авч 8799 буюу 95.6 хувийг олгож, байгууллагын хүсэлтээр 2.9% татгалзаж, 1.5% нь шийдвэрлэлтийн шатандаа явж байна. Үүнд: - Эм-13432 - Урвалж оношлуур-12277 - Эмнэлгийн хэрэгсэл-20599 - Хандив тусламж-1215 - Төрийн хяналт-262 - Мансууруулах сэтгэгцэд нөлөөт эм-110 - Татгалзсан-268
-----	--	--------	-------------------------------	---	--

					- Шийдвэрлэлтийн шатандаа байгаа-134 И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрлийн газарт - Вакцины бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн үйл - Бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн үйл ажиллагааг цахимжуулах хүсэлтийг хүргүүлж, 5 дугаар сарын 03-ны өдрөөс үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн.				
13.	Арга хэмжээ 2.6 Үндэсний эмийн үйлдвэрүүдэд “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал”-ыг бүрэн нэвтрүүлэх	ЭЭХХЗГ	Дотоодын эмийн үйлдвэрүүд “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” (GMP)-ын батламж авсан байна.	Олон улсад Монголын эмийн үйлдвэрийг хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдэнэ.	“Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” GMP-ийн батламж сунгасан үйлдвэр-4. Үүнд: “Нахиа” ХХК, “Энхийн шүүдэр” ХХК, “Айвико” ХХК, “Армон” ХХК эмийн үйлдвэрүүд байна. Батламжаа сунгах хүсэлтийн дагуу ажлын байранд үнэлгээ хийх шинжээчдийг 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн Хүний эмийн зөвлөл (ХЭЗ)-ийн хурлаар томилсон. “Армон” ХХК, “Нахиа” ХХК-нд үнэлгээ хийхээр томилогдсон шинжээч эрүүл мэндийн шалтгааны улмаас ажиллах боломжгүй болсон тул дахин 5 дугаар сарын 20-ний өдрийн ХЭЗ-ийн хурлаар дахин шинжээчдийг томилсон. 6 дугаар сарын 21-ний өдрийн ХЭЗ-ийн хурлаар сунгалтын асуудлыг хэлэлцүүлж, хугацаа сунгах шийдвэр гаргасан. 2024 оны 7 дугаар сард тус 4 үйлдвэрийн батламжийг хүлээлгэн өгсөн.	90			
14.	Арга хэмжээ 2.7 Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шинжээч, байцаагч нарыг чадавхжуулж, мэргэшсэн байцаагч бэлтгэх	ЭЭХХЗГ	Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын мэргэшсэн байцаагч бэлдсэн байна.	Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын үнэлгээ хийх чадавхи нэмэгдэж, эмийн үйлдвэрлэлийн зохистой дадлыг хангах нөхцөл бүрдэнэ.	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргадаг Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын удирдамж шинэчлэн батлагдсантай холбогдуулан удирдамжид нийцүүлэн “Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага” MNS 5524:2014 стандартыг шинэчлэн боловсруулж СХЗГ-т хүргүүлсэн. “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль” дагалдан гарах “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шинжээч сонгон шалгаруулах, ажиллуулах журам”-ыг шинэчлэн боловсруулж байна. Шинэчлэн боловсруулсан журам батлагдаж, GMP-ийн шинжээчдийг ахин шинээр сонгон шалгаруулалт хийсний дараа батлагдсан стандартын дагуу сургалт зохион байгууллахаар төлөвлөж байна.	70			
15.	Арга хэмжээ 2.8 Монгол улсын үндэсний фармакопейг шинэчлэх	ЭЭХХЗГ	Монгол улсын үндэсний фармакопейг шинэчлэгдэн хэвлэгдсэн байна.	Үндэсний болон импортын эмийн бүтээгдэхүүний шинжилгээний арга, аргачлал шинэчлэгдсэн байна.	“Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалтад дотоод болон гадаадын ерөнхий нэршлийн эмийн чанар, аюулгүй байдлыг шинжлэхэд олон улсад зөвшөөрөгдсөн фармакопейг ашиглана гэж заасан учир Монгол улсын үндэсний фармакопейг шинэчлэн боловсруулах шаардлагагүй болсон.	90			
16.	Арга хэмжээ 2.9	ЭЭХХЗГ	Цахим архив орсон эмийн	1994 онос хойшхи	Эмийн бүртгэлийн цахим системд энгийн бүртгэл-18, түргэвчилсэн бүртгэл-37 бодлогоор бүртгэх-1 нийт 56 нэрийн	50			

Эмийн бүртгэлийн архивыг цахимжуулах	бүртгэлийн баримт бичгийн тоо	материалыг оруулсан байна.	эмийн цахим архив үүсгэсэн. Мөн 2020 оны импортын биологийн идэвхт бүтээгдэхүүний шинэ бүртгэл, импортын эмийн шинэ бүртгэл, сунгалт өөрчлөлтийн архивын хөмрөгийн нийт 200 ботинд цахим архив үүсгэсэн.
Арга хэмжээ 2.13 ДЭМБ-ын хуурамч, стандартын бус эмийг мэдээлэх, системд бүрэн холбогдож мэдээлэл солилцдог болох	ЭЭХХЗГ	Хуурамч стандартын бус эс зах зээлд нэвтрэхээс урьдчилан сэргийлсэн байна.	ДЭМБ-ын албан ёсны мэдээллийн сүлжээ "Эрт сэрэмжлүүлэг систем"-ээс нийт 10 удаагийн мэдээлэл ирсэн. Үүнд: 4 сэрэмжлүүлэг, 2 зах зээлийн тандалт хийх мэдээлэл, 1 эргүүлэн татах мэдээлэл, хэлэлцүүлэг болон цахим сургалтад хамрагдах, судалгаа хийх мэдээллүүд ирсэн байна. - Сэрэмжлүүлэг мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсанд тухай бүрт байршуулсан. - Хуурамч стандарт бус эмийн зах зээлийн тандалт хийх, урьдчилан сэргийлэх талаар 01 дүгээр сарын 14-ний өдөр, 3 дугаар сарын 13-ны өдөр ирүүлсэн 20 хуурамч эм, стандартын бус 8 эмэнд тандалт хийхэд манай улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй байсан. - Эргүүлэн татах 27374 цуврал бүхий Карведи денк 25 мг шахмал эмийн бүртгэлийн сунгалт хийгдээгүй тул Денк фарм төлөөлөгчийн газраас 3 дугаар сарын 22-ны өдөр зах зээлд байхгүй талаар 01/1871 албан бичгээр мэдээлсэн. - Гишүүн орнуудын стандартын бус, хуурамч эмийн механизмын талаар үнэлгээний судалгаанд оролцож, үнэлгээг 5 дугаар сарын 27-ны өдөр цахимаар илгээсэн. - Камбож улсын Пномпень хотод 02 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгуулагдах "ДЭМБ-ын Зүүн өмнөд Ази, Номхон далайн баруун бүс дэх дэлхийн тандалт, мониторингийн тогтолцооны төвүүдийн уулзалт" оролцож, 11 дүгээр сарын 17-21-ны өдөр Хуурамч, стандартын бус эмийн механизм, бусад улс орны туршлагын талаар цахим сургалтанд хамрагдсан. - Хуурамч пропиленгликолийн туслах бодисын сэрэмжлүүлгийн дагуу урьдчилан сэргийлэх зорилгоор идэвхитэй тандалтыг 10 дугаар сарын 25-ны өдрийн агентлагийн даргын баталсан удирдамжийн дагуу 4 эмийн үйлдвэр (Тавин ус ХХК, Моносфарм ХХК, Мөнхийн тун ХХК, Цомбо ХХК)-ийн 4 бүтээгдэхүүнд хийсэн. Чанарын шинжилгээг бүрэн шалгуураар /хольц/ үзээгүй учраас эрсдлээс сэргийлэх зөвлөмж өгсөн.

Зорилт 3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээг бэхжүүлэх					
Арга хэмжээ 3.6 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн дараах төгсөлтийн мэргэшүүлэх сургалтын тогтолцоог бүрдүүлэх	ЭМЯ, ЭЭХХЗГ	Зохион байгуулсан сургалт	Инженерүүдийн мэдлэг сайжирч, чадавх сайжирсан байна.	Шинэ төгссөн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч нарт "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээ" сургалтыг Монголын эмнэлгийн инженерчилэлийн нийгэмлэгтэй хамтран зохион байгууллахаар төлөвлөж, сургалтын удирдамж, хөтөлбөрийг боловсруулж, агентлагийн даргаар 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр батлуулсан. Тус сургалтын мэдээллийг эрүүл мэндийн болон эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллагад 10 дугаар сарын 01-ний өдрийн 01/1512 дугаар албан бичгээр хүргүүлж, "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээ" сургалтыг 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад нийт 40 байгууллагын 66 эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч нар хамрагдаж, гэрчилгээ олгосон.	90
19. Арга хэмжээ 3.7 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний тогтолцоог сайжруулах	ЭМЯ, ЭЭХХЗГ	Сайдын тушаал	Чанартай тоног төхөөрөмжөөр тусламж үйлчилгээ үзүүлэх чадавх сайжирна.	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний тогтолцоог сайжруулах чиглэлийн хүрээнд 3 журмын төслийг боловсруулж, 2023 онд ЭМЯ-нд хүргүүлсэн.	90

Жич:

“Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар”-аас тус төлөвлөгөөнд 2024 онд бие даан хэрэгжүүлэх 15 арга хэмжээ, хамтран хэрэгжүүлэх 4 арга хэмжээ тусгагдсан байна. Үүнээс:

№	Арга хэмжээ	Тоо	90 хувь	70 хувь	50 хувь	30 хувь
1	Бие даан хэрэгжүүлэх арга хэмжээ	15	6	4	2	3
2	Хамран хэрэгжүүлэх арга хэмжээ	4	3	-	1	-
3	Нийт хэрэгжүүлэх арга хэмжээ	19	9	4	3	3